

ОЛОН УЛС СУДЛАЛ

ОЛОН УЛС СУДЛАЛ ХХ ЗУУН

Д.Шүрхүү (Ph. D)

1961 онд Монгол улс НҮБ-д элсэн орж дэлхийн хамтын нийгэмлэгт хууль ёсны байр сууриа эзэлсэн явдал олон улсын тавцанд манай орны нэр хүндийг өсгөн, гадаад харилцаа өргөжин тэлэхэд шинэ түлхэц болсон юм. Мөн энэ үед ШУА байгуулагдан Монголын шинжлэх ухаан хөгжлийн шинэ үе шатанд дэвшин орж байгаль нийгмийн шинжлэх ухааны шинэ шинэ салбаруудыг үүсгэн хөгжүүлж байлаа. Ийм шинэ салбарын нэг бол Монгол улсын гадаад харилцаа болон гадаад орон судлах олон улс судлал бөгөөд үүний эхлэл нь ШУА-ийн ерөнхийлөгч, академич Б.Ширэндэвийн санаачлагаар 1968 онд ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын дэргэд анх Ази, Африкийн хэлтэс нэртэйгээр байгуулагдсан Дорно дахины судлалын хүрээлэн судалгааны ажлаа эхэлсэн явдал юм.

1980-аад оны дунд үе хүртэл Дорно дахины судлалын хүрээлэнгийн хамт олон тухайн үеийн Монгол улсын гадаад бодлого болон олон улсын байдалтай нягт уялдсан гуравдахь ертөнцийн орнууд, капиталист биш хөгжлийн зам, БНХАУ-ын улс төр, түүх, соёл, үндэстний асуудлыг голлон судалж байлаа. Энэ үеийн судалгааны үр дүнд “Хөрөнгөтний бус хөгжлийн замаар замнаж буй Ази Африкийн зарим орон” (УБ.1970), “БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орон” (УБ.1981) хамтын бүтээлүүд, “Хятад дахь хэрэг явдал” (УБ.1974-1979) өгүүллийн эмхэтгэлийн цуврал, “Синайн дайн-гурвын түрэмгийлэл” (Д.Маам, УБ.1971), “Гуравдахь ертөнц: эдийн засгийн тусгаар тогтнолын асуудал” (Н.Дангаасүрэн, УБ.1981), “Внутренняя Монголия во второй половине XIX в начале Ххвв.” (Н.Алтанцэцэг, УБ.1981) “БНМАУ, хөгжиж байгаа орнууд” (Л.Хайсандай, УБ.1982), “БНХАУ-ын Синцзян-Уйгурын автономит район” (Л.Бэгзжав, УБ.1984) зэрэг нэг сэдэвт зохиолууд хэвлэгдэв. 1970-1980-аад онуудад Дорно дахины судлалын хүрээлэнгийн анхааран судалж байсан нэг сэдэв бол гадаад орнууд дахь монгол судлал, ялангуяа Монголын түүх бичлэгийн асуудал байсан бөгөөд энэ чиглэлээр “БНМАУ-ын түүх, соёл, түүх бичлэгийн асуудалд” (Ш.Бира, УБ.1977), “БНМАУ-ын түүхийг маогийнхнаас гуйвуулж байгаа ба түүхэн үнэн” (хамтын бүтээл, УБ, 1980), “Хятад, Япон дахь монгол судлал” зэрэг бүтээл гарсан юм.

Мөн үүний зэрэгцээ тус хүрээлэнгээс эрхлэн гаргадаг “Дорно дахины судлалын асуудал” (1978 оноос гарч эхэлсэн) сэтгүүл болон албан хэрэгцээнд зориулсан “Судалгаа мэдээ”, “Танилцуулах мэдээ”-нүүд нь

*. ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга

судлаачид бүтээлээ олон түмэнд хүргэх чухал суваг болж байлаа. Монгол улсад олон улс судлалыг үүсгэн хөгжүүлэхэд Ч.Далай, Л.Жамсран, Н.Дангаасүрэн, Ш.Бира, Н.Ишжамц, Ш.Сандаг нарын эрдэмтэд ихээхэн хувь нэмэр оруулсан билээ.

Энэ үед Дорно дахины судлалын хүрээлэн хуучин социалист системийн орнуудын ижил төстэй байгууллагуудтай хэлхээ тогтоон хамтын бүтээл гаргах, эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах, эрдэмтэд солилцох зэргээр хамтран ажиллаж байлаа.

1985 оноос ЗХУ-д эхэлсэн өөрчлөн байгуулалт, улс төрийн шинэ сэтгэлгээ дэлхий дахинаа олон арван жил ноёрхсон “Хүйтэн дайн”-ы уур амьсгалыг зөөлрүүлэн хүн төрөлхтөн олон улсын шинэ орчинд шилжих үндэс суурь тавигдаж байлаа. Мөн 1970-аад оны сүүлчээр БНХАУ болон Дорнод Европын зарим оронд шинэтгэл, нээлттэй бодлого явуулж эхэлсэн нь энэ үйл явцад эерэг нөлөө үзүүлсэн юм. Олон улсын шинэ нөхцөл байдал манай улсын гадаад бодлогод төдийгүй дотоод байдалд ч тодорхой хэмжээгээр нөлөөлөх болсон нь манай орны олон улс судлалыг ихээхэн урагшлуулан хөгжүүлэх хүчин зүйлийг нөхцөлдүүлж байлаа. 1985 оноос 1990-ээд оны эхэн хүртэлх энэ үе шатанд Дорно дахины судлалын хүрээлэнгийн шинжилгээ судалгааны ажлын хүрээ уламжлалт хятад судлал, үндэстний асуудал, хөгжиж буй орны судалгааны зэрэгцээ Ази, Номхон далайн бүсийн аюулгүй байдал, Хятад дахь шинэтгэл, нээлттэй бодлого, Япон, “Азийн бар” орнуудын хөгжлийн туршлага гэх мэт шинэ судалгаагаар өргөжин тэлсэн билээ. Энэ байдал тус хүрээлэнгийн эрдэмтдийн туурвисан зохиол бүтээлд тусгалаа олсон юм. Тухайлбал, “Өнөөгийн Ази: Дайн энхийн асуудал” (УБ.1989), “Социалист чиг баримжаат орнуудын хөгжлийн зарим асуудал” (УБ.1988), “БНХАУ-ын үндэстний зарим автономит районы байдал” (УБ.1987), “Япон, Азийн барс үсрэнгүй хөгжсөн нь” (УБ.1993) зэрэг хамтын бүтээл, “Монголо-китайские отношения. 1949-1985” (Ч.Далай, Прага.1986), “БНХАУ-ын удирдлагаас ӨМӨЗО-д явуулж буй бодлогын үндсэн чиглэл” (Ц.Батбаяр, УБ.1988) “Монголын сэргэн мандалтын эхэн. 1911-1912 он” (УБ.1992), “Өвөр Монгол: өчигдөр, өнөөдөр” (М.Зэнээ, УБ.1989), “Халхын гол: түүх ба орчин үе” (УБ.1989), “Монголын зэвсгийн товч түүх” (УБ.1990), зэрэг нэг сэдэвт зохиол уншигчдын хүртээл болсон билээ. 1978 оноос гараагаа эхэлсэн Монголын олон улс судлалын анхны хэвлэл болох “Дорно дахины судлал” сэтгүүл 1980-аад оны дунд үеэс манай орны нэр хүндтэй, өргөн олон түмний унших дуртай улс төр, шинжлэх ухаан, танин мэдэхүйн сэтгүүл /2000 хүртэл хувиар хэвлэгддэг/ болсон юм. 1989 оноос Монгол оронд өрнөсөн өөрчлөлт шинэчлэлтийн явцад нийгмийн шинжлэх ухаан ялангуяа орон судлал, гадаад харилцааны судалгаа үзэл суртлын хүдээснээс ангижрахад тус сэтгүүлийн шинэлэг, хурц өгүүллүүд багагүй үүрэг гүйцэтгэсэн юм. Энэ үеийн нэг онцлог бол төр засгаас олон улс судлалыг хөгжүүлэхийг ихэд анхааран чухалчилж олон тооны

мэргэжилтнүүдийг дотоод гадаад бэлтгэсний үрээр тус хүрээлэн мэргэжлийн боловсон хүчээр бэхэжсэн явдал юм, 1980-аад оноос олон улс судлалын чиглэлийн дунд үеийн олон эрдэмтэд төрөн гарсан юм. Манай орны хятад, япон судлал, олон улсын харилцааны мэргэжилтэй боловсон хүчин, эрдэмтэд бэлтгэх үйлст хуучин ЗХУ ихээхэн тус дэмжлэг үзүүлж байсан билээ. 1980-аад оны сүүлчээс эхлэн эрдэм шинжилгээний залуу ажилтнуудыг БНХАУ, Япон, Өмнөд Солонгост мэргэжил дээшлүүлж эхэлсэн нь эрдэм шинжилгээний ажилтнуудын мэргэжлийн ур чадвар, хэлний мэдлэгийг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой байлаа.

Энэ үе шатны бас нэг онцлог бол Монголын олон улс судлалын эрдэмтэд дэлхийн олон орны ялангуяа АНУ, Япон, Солонгос зэрэг өндөр хөгжилтэй орнуудын эрдэмтэдтэй хэлхээ холбоо тогтоон эрдэм шинжилгээ гадаад харилцаа, хамтын ажиллагаа үлэмж өргөжин тэлсэн явдал юм.

1990-ээд оны эхээр манай орны олон улс судлалд гарч ирсэн нэгэн шинэлэг зүйл бол хөрш хоёр орноос гадна Япон, АНУ зэрэг гадаад харилцаа, хамтын ажиллагаа эрчимтэй хөгжиж буй орнуудыг дагнан судлах орон судлалын ажил өргөжин улмаар тухайн орныг судалж буй эрдэмтдийн хүчийг нэгтгэн зохион байгуулах зорилго бүхий олон нийтийн эрдэм судлалын байгууллагууд Дорно дахины судлалын хүрээлэнг түшиглэн байгуулагдсан явдал юм. 1990 оны 1-р сард байгуулагдсан "Монголын хятад судлаачдын холбоо" Дорно дахины судлалын хүрээлэнтэй хамтран Монголд анх удаа хятад судлалын анхны эрдэм шинжилгээний бага хурлуудыг (1990 оны 10-р сард "БНХАУ-ын шинэтгэл, нээлттэй бодлогын үр дүн туршлага", 1991 оны 8-р сард "БНХАУ ба Ази, Номхон далайн бүс нутаг") зохион байгуулсан юм.

1991 оны 1-р сарын 23-нд Монгол улсын ерөнхийлөгч П.Очирбат АНУ-д айлчилж эхэлсэн өдөр ШУА-ийн дорно дахин, олон улс судлалын хүрээлэнгийн дэргэд Монголын АНУ судлалын төв байгуулагдсан билээ. Академич Н.Ишжамцын тэргүүлсэн энэхүү судлаачдын олон нийтийн байгууллага Монгол улсад АНУ судлал хөгжүүлэхэд багагүй хувь нэмэр оруулж байгаа бөгөөд олон удаа эрдэм шинжилгээний семинар, бага хурал, лекц зохион байгуулж, "Америк: судалгаа, мэдээлэл" гэсэн сэтгүүл гаргахын сацуу олон судлаачдыг өөрийн шугамаар янз бүрийн мэргэжил дээшлүүлэх курст явуулж сургаад байна.

1990 оны 3-р сард Монгол улс БНСУ-тай дипломат харилцаа тогтоосны дараахан Дорно дахин, олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтнуудын үүсгэл санаачлагаар Солонгос судлалын төв байгуулагдав. Тус төв нь Монгол улсад солонгос хэлний анхны сургалтыг зохион байгуулснаас гадна БНСУ-ын судалгаа шинжилгээний байгууллагууд болон түүнийг хөхүүлэн дэмждэг сангуудтай ажил төрлийн холбоо тогтоож, сурах бичиг, судалгааны ном, сэтгүүл нийлүүлэх, аспирант, мэргэжил дээшлүүлэгчдийг Солонгост илгээх ажлыг анх зохион

байгуулав. 1991 оноос Солонгос судлалын төвийн шугамаар Солонгосын талын санхүүжилтээр хоёр орны эрдэмтдийн хамтарсан 10 жилийн хугацаатай “Дорнод Монгол” томоохон төсөл амжилттай хэрэгжиж байна.

Монгол улс 1990-ээд оноос үндэсний эрх ашгаа дээдлэн олон тулгуурт, тэнцвэртэй, идэвхитэй гадаад бодлого явуулж эхэлсний зэрэгцээ судалгааны байгууллагуудын тоо нэмэгдэж, судалгаа шинжилгээний ажлын цар хүрээ ихээхэн өргөжсөнтэй уялдан олон улс судлал хөгжлийн шинэ үе шатанд орсон юм. Дорно дахины судлалын хүрээлэнгийн судалгааны цар хүрээ өргөжсөнтэй уялдуулан тус хүрээлэнгийн нэрийг ШУА-ийн ерөнхийлөгчийн захирамжаар 1991 оны 6 дугаар сард Дорно дахин, олон улс судлалын хүрээлэн хэмээн өөрчлөв. Мөн онд Зүүн хойт Ази судлалын төв, Батлан хамгаалах яамны Стратеги судлалын хүрээлэн, МУИС-ийн Олон улсын харилцааны дээд сургууль зэрэг сургалт, эрдэм шинжилгээний шинэ байгууллагууд үүсч олон улс судлал нэг хүрээлэнгийн хүрээнээс гарч нийгмийн шинжлэх ухааны бие даасан салбарын хувьд улс орны нийгэм-улс төрийн амьдралд эзлэх байр сууриа нэлээд бэхжүүлсэн юм.

1990-ээд оны дундуур улс орны төсөв санхүүд учирсан хүндрэлтэй холбогдон төсвөөс судалгаанд зориулах хөрөнгө мөнгөний хэмжээ багасч, олон улс судлалыг голлон эрхлэн хийж байсан Дорно дахин, олон улс судлалын хүрээлэнг Түүхийн хүрээлэнгийн дэргэдэх Олон улс судлалын төв болгон бүтэц зохион байгуулалтын хувьд нэлээд цомхотгосон зэрэг багагүй саад бэрхшээл тохиолдож байсан боловч манай олон улс судлалын чиглэлийн судлаач эрдэмтэд олон тооны ном бүтээл туурвисан юм.

Олон улс судлалын төвөөс хийж буй суурь судалгааны шинжтэй нэлээд дорвитой ажил бол Монгол улсын гадаад харилцааны түүхийг Монголын эзэнт гүрний үеэс өнөөг хүртэл товчоолон судалж байгаа явдал юм. Өнгөрсөн хугацаанд энэ чиглэлээр “Монголын эзэнт гүрний гадаад харилцаа” (УБ,1995), “ХIY-XIX зууны Монголын гадаад харилцаа” (УБ,1997)” хамтын бүтээлүүд, “ХIY-XYI зууны Монгол-Хятадын харилцаа” (Н.Ариунгуа, УБ,1996) нэг сэдэвт зохиол хэвлэгдэн гараад байна.

“Монголын эзэнт гүрний гадаад харилцаа” (УБ,1995) номонд ХIII-XIY зууны дэлхийн түүхэнд монголчуудын гүйцэтгэсэн үүргийг нээн харуулахад чухал ач холбогдолтой Монголын эзэнт гүрний гадаад бодлого, нүүдэл суурьшлын янз бүрийн улс оронтой янз бүрийн түвшинд харилцаж байсан харилцааг нэлээд нарийвчлан судласан байна. Энэхүү номыг зохиогчид гурван тивийн төр улсуудын харилцааны томоохон нэгэн үеийг үнэн зөвөөр танин мэдэхэд төдийгүй Чингис хаан, Монгол гүрний талаар хэвшин тогтсон зарим эндүү ташаа зүйлийг засч залруулахад тус дөхөм болох шинэлэг үнэлэлт дүгнэлтүүд дэвшүүлжээ.

“ХIY-XIX зууны Монголын гадаад харилцаа” (УБ,1997) номонд ХIY-XIX зууны Монголын түүх нь тусгаар тогтносон ба харийн дарлалд

байсан хоёр өөр үе шатыг дамжиж өнгөрсөн учир тэргүүн үед нь биеэ даасан улсын ёсоор гадаадтай харилцаж байсан, дараа үед нь өөрийн гэсэн төр улс, тусгаар тогтнолгүй байсан нөхцөлд гадаадтай харилцаж байсан байдлыг харгалзан доорхи шинэлэг санаа дүгнэлтийг дэвшүүлжээ. Үүнд:

1. XIV-XVII зууны Монгол улсыг феодалын бутралын учир хэд хэд хуваагдчихаад Монгол орон төр улсгүй болчихоод байсан юм шиг бичдэг байсныг өөрчилж, тухайн үеийн Монголын тэдгээр ханлигууд нь тус тусдаа төр засагтай бэсрэгхэн улс байсан учир Монгол улс, түүний тусгаар тогтнол өчүүхэн төдий ч алдагдаагүй, тийм учир гадаадтай тусгаар улсын ёсоор харилцаж байлаа.

2. Манжийн ноёрхлын үед Манж, Хятад, Монгол, Түвд, Хотон аймгууд нэг улс гүрний дотор багтан хамтдаа цуг оршин амьдарч байсан учир Монгол ба манж, хятад, түвд, хотонгийн хоорондын харилцааг гадаад харилцаа биш, дотоод асуудал мэт авч үздэг байсныг өөрчилж Монгол орон, Монгол үндэстний хувьд Манж, Хятад, Түвд, Хотонтой харилцах нь чухамдаа гадаад харилцааны асуудал байсныг цохон тэмдэглэж, Ар Монгол нь тэдгээрээс гадна Орос, Япон зэрэг гадаадын томоохон улс гүрнүүдтэй ч улам бүр их харилцаатай болж байсан зэрэг шинэ санаа дүгнэлт дэвшүүлжээ.

Монгол улсын гадаад харилцааны түүхийг цогц байдлаар шинжлэн судлах ажил 1997-2000 онд хэрэгжүүлэх “XX зууны сэргэн мандлын үеийн Монгол улсын гадаад харилцаа” төслөөр дуусах юм. Энэ судалгаа шинжлэх ухааны төдийгүй танин мэдэхүйн, нэн ялангуяа Монгол улсын гадаад харилцааны үзэл баримтлал, хэтийн төлөвийг боловсруулахад чухал үндэслэл болох практикийн ихээхэн ач холбогдолтой юм.

Тус төвөөс 1992-1995 онд хөрш Орос, Хятад улсууд дахь монголчуудын талаар томоохон судалгаа хийж “Орос дахь монгол угсааны улсууд” (УБ, 1995), “Хятад дахь монголчууд” (УБ, 1996) хамтын бүтээл, “ОХУ-ын БНБуриад улс” (Ч.Батцэцэг, УБ, 1996) товхимол гаргасан нь дотоод гадаадын судлаачид, өргөн олон түмний дунд эрэлт хэрэгцээтэй номуудын тоонд зүй ёсоор оржээ.

1990-ээд онд Олон улс судлалын төвийн хамт олон уламжлалт судалгаануудын нэг болох БНХАУ дахь шинэтгэл, нээлттэй бодлогыг үргэлжлүүлэн судалж хэд хэдэн бүтээл, тухайлбал, “Өнөөгийн Хятад орон” (УБ, 1996), “БНХАУ-ын өөрчлөлт шинэчлэлт, нээлттэй бодлого” (УБ, 1999), “БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө засах орон” (УБ, 1999), БНХАУ-ын түүхийн товч тойм /Нэн эртнээс 1999 он/ (Н.Ишжамц, УБ, 1999) номууд уншигчдын хүртээл болов.

Монгол улсын төрийн тусгаар тогтнолын сэргэлт болон гадаад орчин, гадаад харилцааны хөгжил хувьслыг нээн харуулсан томоохон судалгааны зохиолууд хэвлэгдэн гарлаа. Үүнд: “Монгол ба Япон XX зууны эхэн хагаст.” (Ц.Батбаяр, УБ, 1998), “Монголын төрийн тусгаар тогтнолын

сэргэлт” (Л.Жамсран, УБ.1998), “Монголын гадаад орчин төрийн тусгаар тогтнол” (Б.Лхамсүрэн, УБ.1995) зэрэг бүтээлийг нэрлэж болох юм.

Сүүлийн үед Олон улс судлалын төвөөс хийж эхэлсэн судалгааны бас нэг шинэ чиглэл бол Монгол улсын үндэсний аюулгүй байдал, гадаад эдийн засгийн хамтын ажиллагааны цар хүрээ тэлсэнтэй уялдан гарч ирсэн “гуравдахь түнш” орнуудын судалгаа юм. Энэ судалгааны ажлын гол зорилт бол XXI зуунд чиглэсэн Монгол улсын гадаад харилцааны онол, практикийн үйл ажиллагааг шинжлэх ухааны үүднээс судлан боловсруулах, өөрөөр хэлбэл олон улсын хамтын нийгэмлэгт Монгол улсын байр суурийг хэрхэн бэхжүүлж, олон тулгуурт гадаад бодлогыг хөгжүүлэх замаар улс орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хэрхэн найдвартай хангах асуудлыг судлах явдал юм. Энэхүү судалгааны эхний үр дүн болох “АНУ-аас Монголын хувьд явуулсан бодлого, Монгол-Америкийн харилцаа (1900-1987)” (Н.Ишжамц. УБ.1999) ном хэвлэгдэн гарлаа.

Монгол улс зах зээлийн эдийн засагт шилжиж байгаа одоо үед тохиолдож буй нийгэм эдийн засгийн бэрхшээл, түүнийг гэтлэн давж, цаашид тууштай хөгжих боломжийг эрэн сурвалжилж буй энэ үед өөрийн орныг хөгжүүлэх дотоод, гадаад хүчин зүйлсийг хошуулан судлах, ялангуяа олон улсын харилцаа, гадаад орчинд гарч буй өөрчлөлт шинэчлэлтийг судалж дэлхий, тив, бүс нутгийн хөгжлийн хандлагыг тодорхойлон тэдэнтэй хөл нийлүүлэн алхах боломжийг шинжлэх ухааны үүднээс үндэслэх явдал онцгой шаардлагатай болж ирсэн билээ. Олон улс судлалын чиг хандлага ч гэсэн энэ чиглэл рүү нэлээд түлхүү анхаарах болсон юм. Олон улс судлалын төв дээр дурдсан асуудлыг судлан боловсруулах үүднээс 1993-1996 онуудад “Олон улсын харилцааны шинэ хандлагууд, Монгол улсын гадаад бодлогын ойрын ба хэтийн төлөв”, “Зүүн Азийн орнуудын туршлага, түүнийг Монгол улсын төрийн эдийн засгийн бодлогыг тодорхойлоход харгалзах онол, арга зүйн асуудал” хоёр төсөл хэрэгжүүлсэн бөгөөд түүний үр дүнд “Япон Азийн “барс” үсрэнхгүй хөгжсөн нь”, (УБ.1994), “1990-ээд оны олон улсын харилцааны хандлагууд, Монгол улс-Их гүрнүүдийн харилцаа” (УБ.1995), “Монгол улсын эдийн засгийн хөгжлийн үндэсний чадавхи гадаад орчин” (УБ.1996), “Ази тив, түүний салбар бүс нутгуудын хамтын ажиллагаанд Монголын оролцоо, хэтийн төлөв” (УБ.1997) зэрэг хамтын бүтээлүүд хэвлэгдэн гарав. Эдгээр бүтээлийн агуулгыг авч үзэхэд түүнд Зүүн хойт Ази, Зүүн Өмнөд Ази, Төв Азийн бүс нутгуудын эдийн засгийн өнөөгийн байдал, Монгол улс тэдгээр бүс нутгийн интеграцид оролцох боломж хир байгаа, түүнийг хэрэгжүүлж буй өнөөгийн байдал, хэтийн төлөвийг судлан зохих үнэлэлт дүгнэлт өгсөн судалгаа болов. Судалгаанд XXI зууны гараан дахь дэлхийн эдийн засгийн хөгжлийн хандлагыг шинжлэн судалж XXI зууны эхний хоёр арван жилд буюу 2020 онд ямар болохыг Европ, Азийн соёл иргэншил, Шинжлэх ухаан-Технологи, Техникийн хөгжлийн хурдац

хүний оюуны багтаамж бүхий үйлдвэрлэлийн үйл ажиллагааны түвшингийн үзүүлэлтээр зэрэгцүүлэн үнэлэлт дүгнэлт өгсөн нь шинэлэг зүйл болов.

Ялангуяа зах зээлийн эдийн засгийн өнөөгийн нээлттэй ертөнцөд ямар ч улс орон хэдийгээр их баялаг нөөцтэй ч гэсэн зөвхөн өөрийн хүч хөрөнгөөр бие даан хөөгжих бололцоогүй гэдгийг дээрх үзүүлэлтүүдээр нотлохыг оролдсон байна. Энэхүү оролдлогоос үүдэн улс хоорондын харилцаа, хамтын ажиллагаа олон хэлбэрийг агуулж байгаагийн дотроос бүс нутгийн хамтын ажиллагаа бүр ч ач холбогдолтой болохыг нотолж өгсөн юм. Мөн түүнчлэн хөгжингүй Япон ба шинээр үйлдвэржсэн БНСУ, Тайвань, Гонконг (Сянган), Сингапур болон Тайланд, Малайзын 30-40 жилд үсрэнгүй хөгжсөн туршлагаас үндэслэж, Монгол Улсын хөгжилд түшиглэх үндэсний харьцангуй давуу талууд юу болохыг тодорхойлоод гадаад орчин, гадаад харилцаа, хамтын ажиллагааг ашиглах боломжуудыг сүвэгчлэн бичсэн байна.

Олон улс судлалын төв өөрийн эрхлэн гаргадаг “Дорно дахины судлал” сэтгүүлийг хэвлэгдэх материалын агуулга, цар хүрээ өргөжсөнтэй холбогдуулан 1991 оноос эхлэн “Дорно-Өрнө” нэртэй болгон өөрчилж улирал тутам гаргахаар болсон юм. Мөн үүнээс гадна Монгол орны өнөөгийн байдал, түүний дотор гадаад бодлого, бүс нутгийн хамтын ажиллагааг дэлхийн олон орны эрдэмтэн судлаачид ихээхэн сонирхох болсныг харгалзан 1993 оноос Монголд анх удаа олон улсын харилцааны чиглэлийн “The Mongolian Journal of International Affairs” сэтгүүлийг англи хэл дээр гаргаж эхэлсэн юм. Тус сэтгүүл нь улс орноо гадаад сурталчлах, манай олон улс судлалын эрдэмтдийн бүтээлийг гадаадын уншигчдад хүргэхийн сацуу орон орны судлаачид олон улсын харилцааны тулгамдсан асуудлаар санал бодлоо солилцох аятай боломж бүрдүүлсэн юм.

Монгол Улсын хөгжилд гадаад орчин, гадаад харилцаа, хамтын ажиллагааны үзүүлэх нөлөө, ач холбогдлыг судлах, ялангуяа Ази тив, юуны өмнө Зүүн хойд Азийн бүс нутгийн хөгжлийн хандлага, чиглэлтэй уялдуулан судлах зорилгоор 1991 онд байгуулагдсан ШУА-ийн Зүүн хойт Ази судлалын төв нь өнгөрсөн хугацаанд “Монгол-Хятад, Монгол-Орсын харилцаа, Монгол улсаас Орос, Хятадын талаар явуулах бодлого”, “Монгол ба Зүүн хойт Азийн орнуудын харилцаа орон судлал” гэсэн төслүүдийг амжилттай хэрэгжүүлэв. Эдгээр төслийг хэрэгжүүлсний үр дүнд “Зүүн хойт Ази: эдийн засгийн хамтын ажиллагаа” (УБ.1995), “Монгол-Солонгосын эртний түүхэн харилцаа” (Ч.Далай, УБ.1998), “Монгол-Японы харилцаа: эрт, эдүгээ (УБ.1998), “Монгол-Хятадын харилцаа (1949-1999)” (Л.Бэгзжав, УБ.1999), “Монгол ба үүн хойт Азийн гэр бүл” (Т.Намжил, УБ, 1996), “NORTHEAST ASIAN ECONOMIC COOPERATION” Illinois, 1999 зэрэг хамтын бүтээл, нэг сэдэвт зохиолуудыг хэвлэн гаргав. Мөн тус төвөөс эрхлэн гаргадаг “Зүүн хойт Ази

суудлал” сэтгүүл /1992 оноос/ тус бүс нутгийн асуудлаарх манай орны төдийгүй Япон, Хятад, Солонгос, АНУ зэрэг дэлхийн олон орны эрдэмтдийн санал бодлоо солилцох, судалгааны үр дүнг олон түмэнд хүргэх бас суваг болсон юм.

Монгол улсын Батлан хамгаалах яамны Стратегийн судалгааны хүрээлэн (ССХ) нь Монгол улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлын үндсийг олон улсын болон бүс нутгийн энх тайван аюулгүй байдлын асуудалтай холбон судлах зорилгоор 1991 онд байгуулагдсан билээ. Өнгөрсөн хугацаанд тус хүрээлэн цөмийн зэвсэггүй бүс, түүний олон улсын эрх зүйн үндэс, НҮБ-ын энхийг сахиулагч хүчний үйл ажиллагаа, хэтийн төлөв, Умард Номхон далай, Зүүн хойт Азид аюулгүй байдлын хамтын тогтолцоо бүрдэх төлөв, олон талт яриа хэлэлцээ, мөн түүнчлэн хөрш орнуудын судалгаа явуулж олон тооны ном товхимол, лавлагаа зөвлөмж бэлтгэн практикийн байгууллагуудад шилжүүлжээ. Тухайлбал, “Монгол улсын аюулгүй байдлын орчин” (УБ, 1994), “Regional Security Issues and Mongolia” цуврал, “Монгол улсын Батлан хамгаалахын цагаан ном” (УБ, 1998), “Монгол улсын аюулгүй байдлын орчин: Орос, Монголын судлаачдын үзэл бодол” (УБ, 1999) зэрэг ном товхимол хэвлэгдэн гарчээ. ССХ нь ОХУ, Япон, БНХАУ, АНУ, Казахстан, Англи, Эанэтхэг зэрэг орны ижил төстэй байгууллагуудтай тогтмол уулзалт зохион байгуулах, хамтран ном хэвлэх, судалгааны ном хэвлэл солилцох зэргээр хамтран ажилладаг.

Тус хүрээлэнгээс үндэсний болоод олон улсын аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого, олон улсын харилцааны холбогдолтой мэдээллүүдийг олон нийтэд хүргэх зорилгоор “Стратеги судлал” сэтгүүлийг жилд 2-3 хэвлэн гаргадаг.

МУИС-ийн Олон улсын харилцааны дээд сургуулийн эрдэмтэн багш нар гадаад харилцаа, олон улс судлалын чиглэлийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх ажлын зэрэгцээ “Монголын дипломат товчоон” (Киян Ж.Бор, УБ, 1998), “Дэлхийн бодлого ба олон улсын харилцаа: 90-ээд оны үндсэн хандлага” (Д.Баярхүү, УБ, 1995), “АНУ-ын түүх” (Б.Цолмон, УБ, 1999), “Олон улсын эрх зүй” (М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр, УБ, 1999), “Олон улсын харилцаа ба шинэ дэг журам” (Д.Баярхүү, УБ, 1998) зэрэг судалгааны ном, сурах бичгүүд туурвисан нь Монголын олон улс судлалын хөгжилд багагүй нэмэр хандив болсон юм.

Манай улсын гадаад харилцааны байгууллагад ажиллаж байсан ба одоо ажиллаж буй Л.Хашбат, Ж.Чойнхор, Г.Төмөрчулуун зэрэг дипломатууд өөрсдийн ажлын туршлага, онол-улс төрийн мэдлэгтээ тулгуурлан Монголын гадаад харилцааны түүх, гадаад бодлого судлалын чиглэлээр диссертаци зохиолууд бичиж манай олон улс судлалын хөгжилд зохих хувь нэмэр оруулсан билээ.

Анх Дорнодахины судлалын хүрээлэн дээр төвлөрөн гол төлөв улс төр, үзэл суртлын чиглэлээр хөрш орнууд болон хөгжиж буй орнуудын

хүрээнд судалгаа явуулж эхэлсэн Монголын олон улс судлал өнгөрсөн 30 гаруй жилийн дотор нийгмийн шинжлэх ухааны бие даасан томоохон салбар болон хөгжиж эдүгээ улс орны нийгэм улс төрийн амьдралд улам бүр идэвхитэй үүрэг гүйцэтгэх боллоо. Тус салбарын эрдэмтэн судлаачид “Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал”, “Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Монгол улсын цэргийн номнолын үндэс” зэрэг Монгол улсын гадаад бодлогыг тодорхойлогч гол гол бичиг баримт боловсруулахад идэвхтэй оролцсоноос гадна улс орны аюулгүй байдал, бүс нутгийн хамтын ажиллагаа гэх мэт олон чухал асуудлаар олон улсын эрдэм шинжилгээний бага хурал, симпозиумыг удаа дараа зохион байгуулж, төр засгийн бодлого боловсруулах, шийдвэр огаргах үйл явцад шаардлагатай судалгаа мэдээлэл бэлтгэж өгөх зэргээр улс орны хөгжилд өөрийн зохих хувь нэмрээ оруулсаар байна.

1999 оны 9-р сард Гадаад харилцааны яамны дэргэд Судалгааны төв, 10-р сард ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн Олон улс судлалын төв, Зүүн хойт Ази судлалын төвүүдийг нэгтгэн бие даасан Олон улс судлалын хүрээлэн байгуулсан нь цаашид энэ чиглэлийн судалгааг хөгжүүлэхэд чухал арга хэмжээ болсон юм. Эцэст нь шинэ XXI зуунд дэлхий дахинаа глобалчлал болон бүс нутгийн интеграцчлал улам бүр өсөн нэмэгдэж буйг гэмдэглэх хэрэгтэй байна. 1990-ээд оноос Монгол улсын гадаад, дотоод орчинд эргэлтийн шинжтэй өөрчлөлтүүд гарч Монгол улс ардчилал, зах зээлийн эдийн засгийн замыг эргэлт буцалтгүй сонгон авсан билээ. Гадаад бодлого ч үзэл сурталжсан хэв загвараас ангижирч үндэсний эрх ашгийг дээдэлсэн прагматик шинж чанартай болж байна. Иймд улам бүр шинэчлэгдэн өөрчлөгдөж буй гадаад орчноо танин мэдэх, урьдын түнш орнуудтай харилцаагаа шинэ шатанд гаргахын зэрэгцээ шинэ түншлэл бий болгох зорилттой уялдан түнш нараа сайтар судлах, юуны өмнө тэдний стратегийн сонирхол, өөрийн үндэсний эрх ашгийн зөв охослол дээр тулгуурласан солбилцлын цэгүүдийг сонгон авч гадаад бодлогын орон зайгаа тэлэх, тусгаар тогтнол бүрэн эрхт байдлаа улс төрийн аргаар хангах явдал юу юунаас чухал болоод байна.